



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/165

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан "Зардлын норматив батлах тухай" журам, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Эргэх холбоо-43" хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд иргэдтэй хийх уулзалтыг Хэрлэн суманд зохион байгуулагдахтай холбогдуулан 852.500 /найман зуун тавин хоёр мянга таван зуун/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010756

10... Аймгийн Засаг даргын 2020 оны
дугаар сарын 06 өдрийн 17/46.5
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тсоцоо

№	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Мөнгөн дүн
1	1-р хоол	ш	32	336.000
2	2-р хоол	ш	33	346.000
3	Ус, ундаа, цай	ш	35	170.500
Нийт үнэ				852.500